

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ



**ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАВДУГААР САРЫН ТАЙЛАН**

2026 он

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 5 ДУГААР САРЫН ТАЙЛАН

Сэлэнгэ Бороо -1,2,3, экспедицүүд нь 5 дугаар сарын 5, 8, 12, 13, 17, 21, 24, 26, 27, 30, 31-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн нутагт үүлэнд зориудаар нөлөөлөн хур тунадас нэмэгдүүлэх, хөрсний чийг сайжруулах, зорилгоор цаг агаарын нөхцөл бүрдсэн 8 удаагийн процесст 11 хээрийн үйл ажиллагаа явуулж 45 пуужин зарцуулсан байна. Одоогийн үлдэгдэл 37 ширхэг пуужингийн үлдэгдэлтэй байна. ЦУОШГазар, Иргэний нисэхийн Ерөнхий газартай байгуулсан гэрээг мөрдөн үйл ажиллагаа явуулах бүрдээ зөвшөөрөл авч харвалт хийж байв.

Аймгийн ЗДТГазартай байгуулсан гэрээний дагуу санхүүжилтээр экспедицийн бие бүрэлдүүнд хээрийн ажиллагаа явуулахад шаардлагатай аяны хэрэгсэл, ширээ сандал, гар чийдэн, Чийг, температур мэдрэгч багаж, аяны тогоо, зэргээр хангаж ажиллаа.




Мөн Мандал сумын ЗДТГазартай хамтарч ажиллаж тус сумын зүгээс Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагааг дэмжин явуулын STARLINK хиймэл дагуулын интернет төхөөрөмж хандивлалаа. Тус төхөөрөмжийг экспедицийн үйл ажиллагаанд ашигласанаар сүлжээгүй газар нутагт ч байнгын интернет орчинд байж хиймэл дагуулын мэдээллийг цаг алдалгүй авах нөхцөл бүрдэж байна.



## Сургалт, сурталчилгааны ажлын талаар

УЦУОШТөвийн албан хаагчид болон цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицэд ажиллаж буй албан хаагчдад “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй ба байгууллага дахь хувь хүний харилцаа” сэдэвт сургалтыг аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран танхимаар болон онлайнаар зохион байгууллаа. Мөн сургалтын үеэр ажилтнуудад эрх зүйн мэдлэг олгох үүднээс “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль”-ийн тухай мэдээлэл, сургалтыг хүргэлээ.



### Нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээний сургалт

“Цаг агаарын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ” сэдэвт сургалтыг АДАПТ төсөлтэй хамтран 5 дугаар сарын 21–22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан үүнд Сэлэнгэ аймгийн УЦУОШТөвийн урьдчилан мэдээлэхийн инженер М.Урангоо инженер оролцсон. Дэлхийн цаг уурын байгууллагаас зөвлөж буй “Нөлөөлөлд суурилсан прогноз” мэдээг цаг агаарын аюултай үзэгдлийн урьдчилан мэдээлэх үйл ажиллагаанд ашиглах шинэ арга, технологитой танилцаж, УЦУОСМХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор П.Гомболүүдэв: “Нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ нь гамшигт үзэгдлийн эрсдэлийг урьдчилан тооцоолж, эрт арга хэмжээ авах боломжийг нэмэгдүүлнэ” хэмээн онцоллоо.

**#АДАПТ** төслөөс нийлүүлсэн өндөр хүчин чадлын супер компьютер болон салбарын инженер, техникийн ажилтнуудад зориулсан үе шаттай сургалтуудын үр дүнд цаг агаарын мэдээллийн нарийвчлал сайжирч, эрт сэрэмжлүүлэх тогтолцоог орон нутагт илүү үр дүнтэй нэвтрүүлэх боломж бүрдэж байна.



Нислэгийн цаг уурын төвөөс 2 жил тутамд зохион байгуулдаг нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчилдэг төв, орон нутгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн урьдчилан мэдээлэхийн инженерүүдэд зориулсан мэргэжлийн ур чадварыг хадгалах сургалтыг 2026 оны 5 дугаар сарын 25-наас 29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд уг сургалтад Сэлэнгэ аймгийн УЦУОШТөвийн урьдчилан мэдээлэхийн инженер С.Сүлд-Эрдэнэ, П.Жигүүрцэцэг, М.Урангоо 3 инженер оролцлоо.



### Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан тухай

“Эмнэх” Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран 05 дугаар сарын 06-ны өдөр ажилтан албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа. Үзлэгээр цусны даралт, цусан дахь сахарын хэмжээ, элэгний В С вирус оношилгоо, 18-40 насны албан хаагчдад ДОХ, тэмбүү, БЗХӨ илрүүлэх шинжилгээ, 40-өөс дээш насны албан хаагчдад бүдүүн шулуун гэдэсний хавдрын шинжилгээ зэрэг үзлэг шинжилгээ оношилгоо хийгдлээ. Үзлэгт нийт 23 албан хаагч хамрагдсан.



05 дугаар сарын 15-ны өдөр Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулдаг “Гано эксель” ХХК-тай хамтран бүтэн биеийн оношилгоонд төвийн 16 ажилтныг хамруулсан ба үзлэгт хамрагдсан бүх ажилтанд мэргэжлийн эмч зөвлөгөө өглөө.



3 удаагийн эрүүл мэндийн үзлэг оношилгоог зохион байгуулахад хамрагдсан ажилтнуудын дунд цусан дахь сахарын хэмжээ ихсэх, мөн цусны даралт ихсэх зэрэг өвчлөлүүд зонхилж байсан ба хамт олны дунд эрүүл амьдралын хэв маягийг эрхэмлэх, амьдралын хэв маягаа өөрчлөх сургалт сурталчилгааг цаашид тогтмол зохион байгуулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Жил бүрийн Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд оролцдог ажилтан албан хаагчдыг “Гэнэтийн ослын даатгал”-д хамруулдаг ба өмнө жилийн даатгалын гэрээ 07 дугаар сарын 01-ний өдөр дуусахаар дахин даатгалд хамруулахаар 2.000.000 төгрөгийг төсөвлөөд байна.

## ЦАГ АГААР ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Ажилбар- 1

**700, 500, 300 мб-ын гадаргад:** 2026 оны 05 дугаар сарын 5-ны өдрийн 08 цагийн байдлаар: ОХУ-ын Байгал нуурын баруун хэсэг орчмоор төвтэй өндрийн циклоны салбар хотос Монгол орны хойд хэсгээр байрлаж байсан бөгөөд уг хотосын нөлөөнд Сэлэнгэ аймгийн нутгаар үлшилт нэмэгдэж, салхи ширүүсч зарим сумдын нутгаар хур тунадас орно гэж тооцоолов.



**Үүлшил:** 2026 оны 05 дугаар сарын 5-ны өдрийн 05:00 цагийн Himawari хиймэл дагуулын үүлний зургаар: Нутгийн баруун хойд хэсгээр байсан үүлний масс үүрийн 5-7 цагийн үед манай аймгийн баруун хойд хэсгээр цаашлаад бүх сумдын нутгаар шилжин орж ирсэн, дараагийн үүлний систем нь 12-15 цагийн хооронд нутгийн баруун хойд хэсгээр орж ирэн нийт нутгийг хамрана гэж тооцон өмнөх үүлний системийг бодвол илүү их тунадас унах нөхцөл бүрдэхээр байна гэж тооцоолов.

Уг мэдээллийн дагуу Сэлэнгэ бороо-1 экспедиц нь 2026 оны 05 дугаар сарын 5-ны өдөр Хушаат сумын нутаг “Мэргэний даваа” гэх газарт байрлаж 2 ширхэг пуужин хөөргөж ажилласан.


Акт-№		7
Харвалт хийсэн он		2026.05.05
Хугацаа /цаг, мин/		13 Цаг 37 минут
Засаг захиргааны харъяалал		Хушаат сум
Газрын оноосон нэр		Мэргэний даваа
Газар зүйн солбилцол		( $\lambda=105^{\circ}32'41''$ $\varphi=49^{\circ}43,10$ $h=1050m$ )
Харвалтын үеийн цаг агаарын төлөв байдал	Агаарын температур	2
	Агаарын чийгшил	69
	Агаарын даралт	916
	Салхины чиглэл	320
	Салхины хурд /м/с/	07
Үзэгдэл		нойтон цас
Үүлний хэлбэр, хэмжээ		Sc 10/10
Үүлний үүсэл		Фронтын гаралтай
Газар орчмын даралтын орны байдал		Хотосын нөлөөнд
Газар орчмын фронтын шинж		2 зэргийн хүйтэн фронтын ард
700 гПа гадарга дээрх геопотенциаль орны байдал, урсгалын чиглэл		Хотослог, өндрийн урсгал Баруун хойд
500 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл		Хотослог, өндрийн урсгал Баруун хойд
Харвалт үйлдсэний дараах өөрчлөлт		Эрчимшил нэмэгдсэн

Хамарсан газар нутаг,тунадасны хэмжээ

Нийт нутгаар 0,0мм-4,0мм хүртэлх тунадас орсон





### 2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 05 -НД ОРСОН ТУНАДАСНЫ ЗУРАГ



#### Ажилбар- 2

**700, 500, мб-ын гадаргад:** 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 08 цагийн байдлаар ОХУ-ын Норильск төвтэй өндрийн циклоны салбар хотос Монгол орны хойд хэсгээр байрлаж байв. Уг хотсын нөлөөгөөр Сэлэнгэ аймгийн нутгаар үүлшил нэмэгдэн хур тунадас орох нөхцөл бүрдэнэ гэж тооцоолов.

**Үүлшил:** 2026 оны 05 дугаар сарын 08-ны шөнийн 01:00 цагийн Himawari хиймэл дагуулын зургаар Хөвсгөл, Булганы нутгаар байрлаж байсан үүлний систем 05 цагийн үед Сэлэнгэ аймгийн нутгийг хамран баруунаас зүүн тийш шилжин хөдөлж байв. Уг үүлний системийн чийгийн агууламж ихтэй хэсэг нь 05 дугаар сарын 08-ны өдрийн 06 цагийн үед шилжин ирнэ гэж тооцов. Цаашлаад тус үүлний системээс манай аймгийн нутгаар өдрийн 15, 16 цаг хүртэл тунадас орно гэж тооцоолсон.




Уг мэдээллийн дагуу Сэлэнгэ бороо-1 экспедиц нь 2026 оны 05 дугаар сарын 8-ны өдөр Түшиг сумын нутаг "Улаан овоот" гэх газарт байрлаж 2 ширхэг пуужин хөөргөж ажилласан бол Сэлэнгэ бороо-2 экспедиц Хушаат сумын "Ногоонхунх" гэдэг газраас 3 ширхэг пуужин хөөргөж ажилласан.

Акт-№		8	9
Харвалт хийсэн он		2026.05.08	2026.05.08
Хугацаа /цаг, мин/		09 Цаг 30 минут	11 цаг 40 минут
Засаг захиргааны харъяалал		Хушаат сум	Түшиг сум
Газрын оноосон нэр		Ногоонхунх	Улаан овоот
Газар зүйн солбилцол		$\lambda=105^{\circ}22'85'' \varphi=49^{\circ}49,26 h=860m$	$\lambda=104^{\circ}56'55'' \varphi=50^{\circ}40,00 h=880m$
Харвалтын үеийн цагийн агаарын телев байдал	Агаарын температур	9,9	12
	Агаарын чийгшил	65	62
	Агаарын даралт		
	Салхины чиглэл	240	270
	Салхины хурд /м/с/	02	04
Үзэгдэл		Бороо	Бороо
Үүлний хэлбэр, хэмжээ		NS 10/10	Cb Sc
Үүлний үүсэл		Фронтын гаралтай	Фронтын гаралтай
Газар орчмын даралтын орны байдал		Хотосын нөлөөнд	Хотосын нөлөөнд
Газар орчмын фронтын шинж		1 зэргийн хүйтэн фронтын ард	1 зэргийн хүйтэн фронтын ард
700 гПа гадарга дээрх геопотенциаль орны байдал, урсгалын чиглэл		Хотослог, өндрийн урсгал Баруун	Хотослог, өндрийн урсгал Баруун
500 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл		Хотослог, өндрийн урсгал Баруун	Хотослог, өндрийн урсгал Баруун
Харвалт үйлдсэний дараах өөрчлөлт		Эрчимшил нэмэгдсэн	Эрчимшил нэмэгдсэн
Хамарсан газар нутаг,тунадасны хэмжээ		Нийт нутгаар 0,0мм-2,0мм хүртэлх тунадас орсон	Нийт нутгаар 0,0мм-2,0мм хүртэлх тунадас орсон




### 2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 08 -НД ОРСОН ТУНАДАСНЫ ЗУРАГ



#### Ажилбар-3


**700, 500, мб-ын гадаргад:** 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 08 цагийн байдлаар ОХУ-ын Новосибирск төвтэй өндрийн циклоны салбар хотос Монгол орны баруун хойд хэсгээр байрлаж агаарын урсгалыг баруун өмнөөс зүүн хойш болгож байв. Уг хотсын нөлөөгөөр Сэлэнгэ аймгийн нутгаар үүлшил нэмэгдэн хур тунадас орох нөхцөл бүрдэнэ гэж тооцоолов.

**Үүлшил:** 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 11:00 цагийн Himawari хиймэл дагуулын зургаар Монгол орны баруун хэсгээр байрлаж байсан чийгийн агууламж ихтэй үүл баруун өмнөөс зүүн хойш тийш шилжиж байв. Сэлэнгэ аймгийн нутгаар 19 цагийн үед шилжин ирнэ гэж тооцоолов.



Уг мэдээллийн дагуу Сэлэнгэ бороо-2 экспедиц Цагааннуур сум "Боргио" гэх газраас 1 ширхэг пуужин харвасан бол Бороо-1 экспедиц Хушаат сум "Ногоон хунх" гэх газар байрлаж 2 ширхэг пуужин тус бүр харваж үйлчилсэн байна.


Акт-№		10	11
Харвалт хийсэн он		2026.05.12	2026.05.13
Хугацаа /цаг, мин/		19 Цаг 59 минут	01 Цаг 16 минут
Засаг захиргааны харъяалал		Цагааннуур сум	Хушаат
Газрын оноосон нэр		Боргио толгой	Ногоон хунх
Газар зүйн солбилцол		$\lambda=105^{\circ}16,65$ $\varphi= 50^{\circ}01,960$ $h= 953м$	$\lambda=105^{\circ}22,53$ $\varphi= 49^{\circ}49,17$ $h= 860м$
Харвалтын үеийн цаг агаарын төлөв	Агаарын температур	10,8	9.8
	Агаарын чийгшил	69	65
	Агаарын даралт	915	
	Салхины чиглэл	320	45
	Салхины хурд /м/с/	07	06
Үзэгдэл		бороо	Бороо
Үүлний хэлбэр, хэмжээ		NS 10/10	Ns 10/10
Үүлний үүсэл		Фронтын гаралтай	Фронтын гаралтай
Газар орчмын даралтын орны байдал		Хотосын нөлөөнд	Хотосын нөлөөнд
Газар орчмын фронтын шинж		2 зэргийн хүйтэн фронтын ард	2 зэргийн хүйтэн фронтын ард
700 гПа гадарга дээрх геопотенциаль орны байдал, урсгалын чиглэл		Хотослог, өндрийн урсгал Баруун өмнө	Хотослог, өндрийн урсгал Баруун өмнө
500 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл		Хотослог, өндрийн урсгал Баруун өмнө	Хотослог, өндрийн урсгал Баруун өмнө
Харвалт үйлдсэний дараах өөрчлөлт		өөрчлөлтгүй	өөрчлөлтгүй
Хамарсан газар нутаг, тунадасны хэмжээ		Нийт сумдын нутгаар 0,0-1,5мм хүртэлх тунадас орсон	Нийт сумдын нутгаар 0,0-1,5мм хүртэлх тунадас орсон



**Ажилбар- 4**

**700, 500, мб-ын гадаргад:** 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 08 цагийн байдлаар Монгол орны баруун хэсэгт бага даралтын орон байрлаж агаарын урсгалыг баруун өмнөөс зүүн хойш болгож байв. Уг циклоны нөлөөгөөр Сэлэнгэ аймгийн нутгаар үүлшил нэмэгдэн хур тунадас орох нөхцөл бүрдэнэ гэж тооцоолов.

**Үүлшил:** 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 18:00 цагийн Himawari хиймэл дагуулын зургаар Монгол орны баруун хэсгээр байрлаж байсан чийгийн агууламж ихтэй үүл баруун өмнөөс зүүн хойш тийш шилжиж байв. Сэлэнгэ аймгийн нутгаар 17-ны 06 цагийн үед шилжин ирнэ гэж тооцоолов.




Уг мэдээллийн дагуу Сэлэнгэ бороо-2 экспедиц Хүдэр сум “Арвин бэлчир” гэх газраас 11 цагт 13 минутанд 2 ширхэг пуужин, 16 цаг 18 минутан 1 ширхэг пуужин харвасан бол Бороо-1 экспедиц Түшиг сум “Улаан овоот” гэх газар байрлаж 2ширхэг пуужин харваж ажилласан байна..

Акт-№	12,13	14	
Харвалт хийсэн он	2026.05.17	2026.05.18	
Хугацаа /цаг, мин/	11 Цаг 13 минут	18 Цаг 35 минут	
Засаг захиргааны харъяалал	Хүдэр сум	Түшиг	
Газрын оноосон нэр	Арвин бэлчир	Улаан овоот	
Газар зүйн солбилцол	$\lambda=107^{\circ}24,16$ $\varphi=49^{\circ}43,57$ $h=850$ м	$\lambda=104^{\circ}56,54$ $\varphi=50^{\circ}19,3$ $h=867$ м	
Харвалтын үеийн цаг агаарын төлөв	Агаарын температур	11,2	9.8
	Агаарын чийгшил	61	65
	Агаарын даралт	921	
	Салхины чиглэл	200	270
	Салхины хурд /м/с/	04	06
Үзэгдэл	бороо	Бороо	
Үүлний хэлбэр, хэмжээ	Сь NS 10/10	Ns 10/10	
Үүлний үүсэл	Фронтын гаралтай	Фронтын гаралтай	
Газар орчмын даралтын орны байдал	Циклоны нөлөөнд	Циклоны нөлөөнд	
Газар орчмын фронтын шинж	2 зэргийн хүйтэн фронтын ард	2 зэргийн хүйтэн фронтын ард	
700 гПа гадарга дээрх геопотенциаль орны байдал, урсгалын чиглэл	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун өмнө	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун өмнө	
500 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун өмнө	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун өмнө	
Харвалт үйлдсэний дараах өөрчлөлт	Эрчимшил нэмэгдсэн	Эрчимшил нэмэгдсэн	
Хамарсан газар нутаг, тунадасны хэмжээ	Нийт сумдын нутгаар 0,8-9,4мм хүртэлх тунадас орсон	Нийт сумдын нутгаар 0,8-9,4мм хүртэлх тунадас орсон	




2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 17 -НД ОРСОН ТУНАДАСНЫ ЗУРАГ



**Ажилбар- 5**

**700, 500, мб-ын гадаргад:** 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 20 цагийн байдлаар Монгол улсын Завхан төвтэй өндрийн циклоны нөлөөнд Монгол орны төв болон баруун хэсгийг байрлаж байв. Уг циклоны нөлөөнд Сэлэнгэ аймгийн нутаг орсон бөгөөд 500, 700гПа-ын өндрийн зургаар бага даралтын орон дайран өнгөрөхөөр байв. Тус бага даралтын орон нөлөөнд Сэлэнгэ аймгийн нутгийг хамран чийгийн агууламж ихтэй үүлний масс шилжин ирнэ гэж тооцов.




**Үүлшил:** 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 20:00 цагийн Himawari хиймэл дагуулын зургаар Монгол орны баруун, төв болон хойд хэсгээр байрлаж байсан чийгийн агууламж ихтэй үүл Сэлэнгэ аймгийн нутгийг хамран 20-ны 23 цагийн үед баруун өмнөөс зүүн урагш шилжин ирнэ гэж тооцов. Мөн циклоны эргэлэгээр чийгийн агууламж ихтэй үүлний систем Сэлэнгэ аймгийн нутаг дээр эргэлдэнэ гэж үзсэн бөгөөд тус үүлний систем 05 дугаар сарын 21-ны өдрийн 08 цагийн үед шилжин ирнэ гэж тооцов.

Уг мэдээллийн дагуу Сэлэнгэ бороо-1 экспедиц Баянгол сум "Баруун урт" гэх газраас 2 ширхэг пуужин, Мандал сум "Улаан даваа" гэх газраас 2 ширхэг пуужин харвасан бол Сэлэнгэ Бороо-2 экспедиц Хүдэр сум "Арвин бэлчир" гэдэг газраас 2 ширхэг пуужин, Сэлэнгэ бороо-3 экспедиц Хушаат сум "Мянгадар уул"-нд байлаж 2 ширхэг пуужин тус бүх харваж үйлчилсэн байна.

Акт-№		15,16	17	18
Харвалт хийсэн он		2026.05.21	2026.05.21	2026.05.21
Хугацаа /цаг, мин/		03 Цаг 43 минут	06 Цаг 04 минут	01 цаг 22 минут
Засаг захиргааны харъяалал		Баянгол сум	Хүдэр	Хушаат
Газрын оноосон нэр		Баруун урт	Арвинбэлчир	Мянгадар уул
Газар зүйн солбилцол		$\lambda=106^{\circ}03,51$ $\varphi= 48^{\circ}49,09$ $h= 945м$	$\lambda=107^{\circ}24,16$ $\varphi= 49^{\circ}43,57$ $h= 850м$	$\lambda=105^{\circ}59,57$ $\varphi= 49^{\circ}50,05$ $h= 850м$
Харвалтын үеийн цаг агаарын төлөв байдал	Агаарын температур	9,8	11,2	8,7
	Агаарын чийгшил	75	81	87
	Агаарын даралт	900	920	913
	Салхины чиглэл	330	045	270
	Салхины хурд /м/с/	06	04	06
Үзэгдэл		бороо	Бороо	Бороо
Үүлний хэмжээ		Сь NS 10/10	Ns 10/10	Ns 10/10
Үүлний үүсэл		Фронтын гаралтай	Фронтын гаралтай	Фронтын гаралтай
Газар орчмын даралтын орны		Циклоны нөлөөнд	Циклоны нөлөөнд	Циклоны нөлөөнд


байдал				
Газар орчмын фронтын шинж	1 зэргийн хүйтэн фронт	1 зэргийн хүйтэн фронт	1 зэргийн хүйтэн фронт	1 зэргийн хүйтэн фронт
700 гПа гадарга дээрх геопотенциаль орны байдал, урсгалын чиглэл	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун хойноос	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун хойноос	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун хойноос	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун хойноос
500 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун хойноос	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун хойноос	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун хойноос	Циклоны нөлөөнд өндрийн урсгал Баруун хойноос
Харвалт үйлдсэний дараах өөрчлөлт	Эрчимшил нэмэгдсэн	Эрчимшил нэмэгдсэн	Эрчимшил нэмэгдсэн	Эрчимшил нэмэгдсэн
Хамарсан газар нутаг, тунадасны хэмжээ	Нийт сумдын нутгаар 1,0-9,0мм хүртэлх тунадас орсон	Нийт сумдын нутгаар 1,0-9,0мм хүртэлх тунадас орсон	Нийт сумдын нутгаар 1,0-9,0мм хүртэлх тунадас орсон	Нийт сумдын нутгаар 1,0-9,0мм хүртэлх тунадас орсон



#### Ажилбар-6

**700, 500, мб-ын гадаргад:** 2026 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 08 цагийн байдлаар ОХУ-ын Северо Енисейский төвтэй өндрийн циклоны салбар хотос Монгол орны хойд хэсгээр байрлаж байв. Уг хотсын нөлөөгөөр дээд давхаргад хүйтэн агаарын адвекц явагдаж, агаарын босоо хөдөлгөөн эрчимжиж, Сэлэнгэ аймгийн нутгаар үүлшил

нэмэгдэн хур тунадас орох мөн изогипсийн шигүүсэл болон температурын зөрүүний нөлөөгөөр салхины хурд аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч шуурахгүй гэж тооцоолов.




**Үүлшил:** 2026 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 16:00 цагийн Himawari хиймэл дагуулын зургаар Архангай, Булган, Эрдэнэт аймгуудаар байрлаж байсан үүлний систем 16 цагийн үед Сэлэнгэ аймгийн нутгийг хамран баруун өмнөөс зүүн хойш шилжин хөдөлж байв. Уг үүлний системийн чийгийн агууламж ихтэй хэсэг нь 05 дугаар сарын 23-ны өдрийн 20 цагийн үед шилжин ирнэ гэж тооцов.

Уг мэдээллийн дагуу Сэлэнгэ бороо-1 экспедиц Хүдэр сум "Арвин бэлчир" гэх газраас 2 ширхэг пуужин, Сэлэнгэ Бороо-2 экспедиц Баянгол сум "Хустайн даваа" гэдэг газраас 3 ширхэг пуужин хөөргөж ажилласан.

Акт-№		19	20
Харвалт хийсэн он		2026.05.23	2026.05.23
Хугацаа /цаг, мин/		20 Цаг 18 минут	21 Цаг 09 минут
Засаг захиргааны харъяалал		Хүдэр сум	Баянгол
Газрын оноосон нэр		Арвин бэлчир	Хустайн даваа
Газар зүйн солбилцол		$\lambda=107^{\circ}24,16$ $\varphi= 49^{\circ}43,57$ $h= 850m$	$\lambda=106^{\circ}02,23$ $\varphi= 49^{\circ}04,32$ $h= 850m$
Харвалтын үеийн цаг агаарын төлөв байдал	Агаарын температур	5,2	7,5
	Агаарын чийгшил	81	76
	Агаарын даралт	912	912
	Салхины чиглэл	320	315
	Салхины хурд /м/с/	06	08
Үзэгдэл		бороо	Бороо
Үүлний хэлбэр, хэмжээ		Cb NS 10/10	Ns 10/10
Үүлний үүсэл		Фронтын гаралтай	Фронтын гаралтай
Газар орчмын даралтын орны байдал		Хотос	Хотос
Газар орчмын фронтын шинж		2 зэргийн хүйтэн фронтын ард	2 зэргийн хүйтэн фронтын ард
700 гПа гадарга дээрх геопотенциаль орны байдал, урсгалын чиглэл		Хотос нөлөөнд өндрийн урсгал Баруун өмнө	Хотос нөлөөнд өндрийн урсгал Баруун өмнө
500 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл		Хотос нөлөөнд өндрийн урсгал Баруун өмнө	Хотос нөлөөнд өндрийн урсгал Баруун өмнө
Харвалт үйлдсэний дараах өөрчлөлт		Эрчимшил нэмэгдсэн	Эрчимшил нэмэгдсэн
Хамарсан газар нутаг,тунадасны хэмжээ		Нийт сумдын нутгаар 0,0-4мм хүртэлх тунадас орсон	Нийт сумдын нутгаар 0,0-4мм хүртэлх тунадас орсон




## 2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 24 -НД ОРСОН ТУНАДАСНЫ ЗУРАГ



### Ажилбар-7

**700, 500, мб-ын гадаргад:** 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 08 цагийн байдлаар ОХУ-ын Красноярскийн хязгаарын өмнөд хэсэг орчим төвтэй өндрийн циклоны хотос Монгол орны хойд хэсгээр нөлөөлж байв. Уг хотосын нөлөөгөөр Сэлэнгэ аймгийн нутгаар хүйтэн агаарын адвекц явагдаж, агаарын босоо хөдөлгөөн эрчимжсэн байна. Үүний улмаас үлшил нэмэгдэж, хур тунадас орох нөхцөл бүрдсэн. Мөн изогипсийн шигүүсэл нэмэгдсэнээр салхи ширүүсэх төлөвтэй байсан боловч аюултай үзэгдлийн хэмжээнд хүрэхгүй гэж тооцов.



**Үүлшил:** 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 09:00 цагийн Himawari хиймэл дагуулын зургаар Төв аймаг орчимд байрлаж байсан үүлний систем Сэлэнгэ аймгийн нутгаар өмнөөс хойш чиглэлтэй шилжин хөдөлж байв. Уг үүлний системийн чийгийн агууламж ихтэй хэсэг нь 05 дугаар сарын 26-ны өдрийн 12 цагийн орчимд Сэлэнгэ аймгийн нутагт нөлөөлөхөөр байлаа. Цаашид үүлний урсгалын чиглэл өөрчлөгдөн, 17:00 цагаас хойш зүүнээс баруун тийш шилжин хөдөлж, аймгийн нутгаар үүлшил хадгалагдан, зарим газраар хур тунадас үргэлжлэн орох нөхцөл бүрдэнэ гэж тооцов. Сэлэнгэ аймгийн


нутгаар үүлний систем идэвхтэй нөлөөлж, Үүлшил нэмэгдэн, зарим газраар бороо, аадар бороо орох нөхцөлтэй байв.

Уг мэдээллийн дагуу Сэлэнгэ бороо-2 экспедиц нь 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Орхон сумын нутаг "Бэлэн далай" гэх газарт байрлаж 2 ширхэг пуужин хөөргөж ажилласан бол Бороо-1 экспедиц Баянгол сум "Баянцогт хайрхан"-аас 2 ширхэг пуужин, Мандал сум "Баавгайтын ам" гэх газраас 2 ширхэг пуужин хөөргөж ажиллсан.

Акт-№		21	22	23
Харвалт хийсэн он		2026.05.26	2026.05.26	2026.05.26
Хугацаа /цаг, мин/		22 Цаг 13 минут	16 Цаг 22 минут	19 цаг 42 минут
Засаг захиргааны харъяалал		Орхон сум	Мандал сум	Баянгол сум
Газрын оноосон нэр		Бэлэн далай	Баавгайтын ам	Баянцогт хайрхан
Газар зүйн солбилцол		$\lambda=105^{\circ}28,17$ $\varphi= 49^{\circ}05,20$ $h=813m$	$\lambda=106^{\circ}30,18$ $\varphi= 48^{\circ}43,43$ $h= 1150m$	$\lambda=106^{\circ}07,20$ $\varphi= 48^{\circ}48,20$ $h= 1010m$
Харвалтын үеийн цаг агаарын төлөв байдал	Агаарын температур	11	15,8	8,7
	Агаарын чийгшил	71	65	89
	Агаарын даралт	927	909	919
	Салхины чиглэл	060	060	160
	Салхины хурд /м/с/	05	05	04
Үзэгдэл		бороо	бороо	бороо
Үүлний хэлбэр, хэмжээ		Ns 10/10	Cb Ns 10/10	Cb Ns 10/10
Үүлний үүсэл		Фронтын гаралтай	Фронтын гаралтай	
Газар орчмын даралтын орны байдал		Хотосын нөлөөнд	Хотосын нөлөөнд	
Газар орчмын фронтын шинж		2 зэргийн хүйтэн фронтын ард	2 зэргийн хүйтэн фронтын ард	
700 гПа гадарга дээрх геопотенциаль орны байдал, урсгалын чиглэл		Хотосын нөлөөнд өндрийн урсгал баруун өмнө	Хотосын нөлөөнд өндрийн урсгал баруун өмнө	
500 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл		Хотосын нөлөөнд өндрийн урсгал өмнөөс	Хотосын нөлөөнд өндрийн урсгал өмнөөс	
Харвалт үйлдсэний дараах өөрчлөлт		Эрчимшил нэмэгдсэн	Эрчимшил нэмэгдсэн	
Хамарсан газар нутаг, тунадасны хэмжээ		Нийт нутгаар 0,7мм-13,3мм хүртэлх тунадас орсон	Нийт нутгаар 0,7мм-13,3мм хүртэлх тунадас орсон	Нийт нутгаар 0,7мм-13,3мм хүртэлх тунадас орсон




### 2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 26,27-НД ОРСОН ТУНАДАСНЫ ЗУРАГ



#### Ажилбар- 8

**700, 500, мб-ын гадаргад:** 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 08 цагийн байдлаар ОХУ-ын Красноярскийн өмнөд хэсэг орчим төвтэй өндрийн циклоны Монгол орны хойд хэсэгт нөлөөлж байв. Уг хотосын урд болон баруун урд захын нөлөөгөөр Сэлэнгэ аймаг орчимд хойд өргөргийн сэрүүн агаарын урсгал давамгайлж, хүйтэн агаарын адвекц ажиглагдсан. Хотосын өмнөд хэсэгт циклон мушгиралтын адвекц нэмэгдэж, дээд давхаргын дивергенцийн нөлөөгөөр агаарын дээшлэх хөдөлгөөн эрчимжсэн байна. Үүний улмаас босоо хөгжилтэй үлшил нэмэгдэх, хур тунадас орох нөхцөл бүрэлдэж байна. Мөн Сэлэнгэ аймаг орчимд изогипсийн шигүүсэл ихсэж, геопотенциалын градиент нэмэгдсэнээр салхины хурд ширүүсэх төлөвтэй байсан боловч 700–500 гПа-ийн зураг харьцуулж үзэхэд салхины эрчим нь аюултай болон гамшигт үзэгдлийн хэмжээнд хүрэхгүй гэж үзэв.




**Үлшил:** 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 10:00 цагийн Himawari хиймэл дагуулын зургаар: Монгол орны хойд болон төвийн нутгийг хамарсан өргөн хүрээний үүлний систем ажиглагдаж байв. Сэлэнгэ аймаг орчимд зузаан давхраат болон босоо хөгжилийн үүл хөгжиж үүлний урсгал баруун хойноос зүүн урагш чиглэлтэй байв. Сэлэнгэ аймгийн нутгаар үлшил ихсэж, зарим газраар бороо, аадар бороо орох нөхцөл бүрэлдсэн байна. Ялангуяа өндрийн циклоны өмнөд хэсгийн өргөгдөл болон циклон

мушгиралтын эерэг адвекцийн нөлөөгөөр хур тунадасны эрчим түр хугацаагаар нэмэгдэх боломжтой байна.


Уг мэдээллийн дагуу Сэлэнгэ бороо-2 экспедиц нь 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Хушаат сумын нутаг "Мэргэний даваа" гэх газарт байрлаж 4 ширхэг пуужин хөөргөж ажилласан бол Бороо-1 экспедиц Цагааннуур сум "Нам даваа"-аас 2 ширхэг пуужин хөөргөж ажилласан байна.

Акт-№		24	25	28
Харвалт хийсэн он		2026.05.30	2026.05.30	2026.05.30
Хугацаа /цаг, мин/		15 Цаг 19 минут	17 Цаг 05 минут	13 цаг 26 минут
Засаг захиргааны харъяалал		Хушаат сум	Хушаат сум	Цагааннуур
Газрын оноосон нэр		Мэргэний даваа	Мэргэний даваа	Нам даваа
Газар зүйн солбилцол		$\lambda=105^{\circ}30,17$ $\varphi=49^{\circ}45,2$ $h=1079м$	$\lambda=105^{\circ}30,17$ $\varphi=49^{\circ}45,2$ $h=1079м$	$\lambda=105^{\circ}19'47''$ $\varphi=50^{\circ}09'41,8''$ $h=953м$
Харвалтын үеийн цаг агаарын төлөв байдал	Агаарын температур	14.2	15,8	14.9
	Агаарын чийгшил	64	71	68
	Агаарын даралт	915	918	915
	Салхины чиглэл	045	360	045
	Салхины хурд /м/с/	08	05	07
Үзэгдэл		бороо	бороо	бороо
Үүлний хэлбэр, хэмжээ		Sc, Cu 10/10	Ns 10/10	Cb Ns 10/10
Үүлний үүсэл		Фронтын гаралтай	Фронтын гаралтай	Фронтын гаралтай
Газар орчмын даралтын орны байдал		Циклоны нөлөөнд	Циклоны нөлөөнд	Циклоны нөлөөнд
Газар орчмын фронтын шинж		1 зэргийн хүйтэн фронтын ард	1 зэргийн хүйтэн фронтын ард	1 зэргийн хүйтэн фронтын ард
700 гПа гадарга дээрх геопотенциаль орны байдал, урсгалын чиглэл		Хотосын нөлөөнд өндрийн урсгал баруун өмнө	Хотослог, өндрийн урсгал Баруун хойд	Хотослог, өндрийн урсгал Баруун хойд
500 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл		Циклоны нөлөөнд өндрийн урсгал баруун өмнө	Циклоны нөлөөнд өндрийн урсгал баруун өмнө	Циклоны нөлөөнд өндрийн урсгал баруун өмнө
Харвалт үйлдсэний дараах өөрчлөлт		Эрчимшил нэмэгдсэн	Эрчимшил нэмэгдсэн	Эрчимшил нэмэгдсэн
Хамарсан газар нутаг, тунадасны хэмжээ		Нийт нутгаар 0,0мм-13мм хүртэлх тунадас орсон	Нийт нутгаар 0,0мм-13мм хүртэлх тунадас орсон	Нийт нутгаар 0,0мм-13мм хүртэлх тунадас орсон



**Ажилбар-9**

**700, 500, мб-ын гадаргад:** 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 08 цагийн байдлаар ОХУ-ын Красноярскийн өмнөд хэсэг орчим төвтэй өндрийн циклоны салбар хотос Монгол орны Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудын нутгаар нөлөөлж байв. Уг хотосын нөлөөгөөр Сэлэнгэ аймаг орчимд хойд өргөргийн сэрүүн агаарын урсгал давамгайлж, хүйтэн агаарын адвекц ажиглагдаж байна. Төв болон хойд бүс нутгаар босоо хөгжилтэй үүлшил нэмэгдэж, түр зуурын хур тунадас, аадар бороо орох нөхцөл бүрэлдсэн байна. Мөн Сэлэнгэ аймаг орчим изогипсийн шигүүсэл их байгаа нь геопотенциалын градиент өндөр байгааг илтгэж байна. Гэсэн х 700 гПа-ын зураг үнэлэхэд салхины эрчим нь аюултай болон гамшигт үзэгдлийн хэмжээнд хүрэхгүй гэж үзэв.



**Үүлшил:** 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 10:00 цагийн Himawari хиймэл дагуулын зургаар: Монгол орны хойд болон төвийн нутгийг хамарсан өргөн хүрээний үүлний систем ажиглагдаж байв. Сэлэнгэ аймаг орчимд давхраат болон босоо хөгжилийн үүл хөгжиж үүлний урсгал баруун хойноос зүүн урагш чиглэлтэй байв. Сэлэнгэ

аймгийн нутгаар үүлшил ихсэж, зарим газраар бороо, аадар бороо орох нөхцөл бүрдэнэ гэж тооцоолов.


Уг мэдээллийн дагуу Сэлэнгэ бороо-2 экспедиц нь 2026 оны 05 дугаар сарын 31-ны өдөр Хушаат сумын нутаг "Ногоонхунх" гэх газарт байрлаж 3 ширхэг пуужин хөөргөж ажилласан бол Бороо-1 экспедиц Хүдэр сум "Арвин бэлчир" гэдэг газраас 2 ширхэг пуужин хөөргөж ажилласан байна.

Акт-№		26	29
Харвалт хийсэн он		2026.05.31	2026.05.31
Хугацаа /цаг, мин/		12 Цаг 54 минут	14 Цаг 26 минут
Засаг захиргааны харъяалал		Хушаат сум	Хүдэр сум
Газрын оноосон нэр		Ногоонхунх	Арвин бэлчир
Газар зүйн солбилцол		$\lambda=105^{\circ}22,54$ $\varphi=49^{\circ}49,22$ $h=805m$	$\lambda=107^{\circ}16'23''$ $\varphi=49^{\circ}43'48''$ $h=878m$
Харвалтын үеийн цаг агаарын төлөв	Агаарын температур	15,2	14,8
	Агаарын чийгшил	80	63
	Агаарын даралт	915	931
	Салхины чиглэл	315	270
	Салхины хурд /м/с/	05	02
Үзэгдэл		бороо	бороо
Үүлний хэлбэр, хэмжээ		Cu cong Cb 10/10	Cb Ns 10/10
Үүлний үүсэл		Хотосын гаралтай	Хотосын гаралтай
Газар орчмын даралтын орны байдал		Хотосын нөлөөнд	Хотосын нөлөөнд
Газар орчмын фронтын шинж		2 зэргийн хүйтэн фронтын ард	2 зэргийн хүйтэн фронтын ард
700 гПа гадарга дээрх геопотенциаль орны байдал, урсгалын чиглэл		Хотослог, өндрийн урсгал Баруун хойд	Хотослог, өндрийн урсгал Баруун хойд
500 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл		Хотослог, өндрийн урсгал Баруун хойд	Хотослог, өндрийн урсгал Баруун хойд
Харвалт үйлдсэний дараах өөрчлөлт		Эрчимшил нэмэгдсэн	Эрчимшил нэмэгдсэн
Хамарсан газар нутаг, тунадасны хэмжээ		Нийт нутгаар 0,3мм-8.2мм хүртэлх тунадас орсон	Нийт нутгаар 0,3мм-8.2мм хүртэлх тунадас орсон



## 5 ДУГААР САРЫН ХУР ТУНАДАС

Сэлэнгэ аймгийн нутгаар 5-р сард олон жилийн дундажтай харьцуулахад 1.9 мм-р бага тунадас бага орсон байна. Сумдаар авч үзвэл Сүхбаатар, Ерөө, Орхонтуул, сумдын нутгаар олон жилийн дундажтай харьцуулахад 0,3-3,0 мм-р ахиу тунадас, харин Баянгол, Орхон, Мандал, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Түшиг, Бугант, Хүдэр, Хушаат сумдын нутгаар олон жилийн дундажтай харьцуулахад 0,5-8,9 мм-р бага тунадас орлоо.




2026 оны 5-р сарын хур тунадасны нийлбэр, мм-ээр

№	Станц, харуул	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	ийлбэр	ОЖД		
1	Сүхбаатар	0.0							2				0.5	1.0	1.0		0.5					3.0	0.6	0.4			0.4			13.0	5.0	27.4	26.1			
2	Баруунхараа					0.0																1.4		0.9	0.3	13.0				3.0	3.0	21.6	25.7			
3	Орхон					2.0											0.8				0.0	1.2					1.7				8.8	4.8	19.3	24.8		
4	Ерөө												0.3	0.0	0.3		2.0	0.7			0.0	2.9		0.4	0.0	0.4					5.8	8.2	21.0	18.0		
5	Орхонтуул					4.0			2								2.0	0.3				4.4		0.0			0.0					10.2	5.3	25.9	25.6	
6	Цагааннуур								0.4				0.1		2.0		2.0	0.3				6.3	1.0									3.0	3.1	18.2	18.7	
7	Зүүнхараа					0.4			0								4.0				0.0	1.0		1.0	1.0	7.0						4.0	2.0	20.4	22.2	
8	Баруунбүрэн					1.0			2								0.0					2.0											6.0	5.0	16.0	18.4
9	Зүүнбүрэн	0.0							0.5				0.0	0.5	0.0		3.0					2.0	0.4	0.4								8.0	5.0	19.8	22.9	
10	Зэлтэр								0.3				0.0		0.7		9.4	2.5				9.0	2.0									0.0	0.3	24.2	18.0	
11	Хүдэр					0.0							0.0	0.7	0.8	0.0	1.0	0.0				1.3		4.0	0.0	0.0						13.0	2.0	22.8	30.3	
12	Бугант												0.0	1.0		0.9	1.0					3.0		4.0	0.4	0.8						13.0	5.0	29.1	30.7	
13	Хушаат					0			0.2				0.4	0.4	0.2		1.0	1.0				3.0	0.0	0.4		1.0						1.0	4.2	12.8	21.7	
14	Дундаж	0.0				1.1			0.9				1.3	3.6	5.0	0.9	24.7	4.5			0.0	3.1	0.8	1.3	0.3	2.7					6.8	4.1	61.1	23.3		

ЦАЗН ажиллагаа явуулсан өдөр


## ХӨДӨӨ АЖ АХУЙН ЦАГ УУР

**Бэлчээрийн ургамал** 5-дугаар сарын 10-ны байдлаар ургамлын ургалтын байдал 50 орчим хувьд сайн, 50 гаруй хувьд дунд. Ургамлын дундаж өндөр 2-6см. 5-дугаар сарын 31-ний байдлаар ургамлын ургалтын байдал 60 хувьд сайн, 40 хувьд дунд. Орхон, Орхонтуул, Мандал, Цагааннуур, Түшиг, Бугант сумдын нутгаар 1.3-2.2ц/га, бусад сумдын нутгаар 0.1-0.8ц/га, ургамлын дундаж өндөр 4-11см байлаа.



дунд  
сайн

/ 5-дугаар сарын 10-ны байдлаар/



дунд  
сайн

/ 5-дугаар сарын 31-ний байдлаар/

**Таримал ургамал** Улаанбуудайн ургалтын байдал ихэнх сумдын нутгаар сайн, Цагааннуур, Баянгол соёлолт, Орхон, Ерөө Орхонтуул сумдын нутгаар цухуйлтын үе шат ажиглагдсан.



**Хөрсний байнгын чийг:** 5 дугаар сард 0-20см-ийн гүнд Цагааннуур хангалттай, Ерөө, Мандал, Орхонтуул дунд, бусад сумдын нутгаар хангалтгүй, 0-50см-ийн гүнд Цагааннуур, Орхонтуул хангалттай, Мандал, Ерөө дунд, Орхон, Баянгол хангалтгүй.

**Бэлчээрийн талбай** 5 дугаар сард 0-20см-ийн гүнд Баянгол хангалтгүй, Орхон дунд, Ерөө хангалттай, 0-50см-ийн гүнд Баянгол хангалтгүй, Ерөө, Орхон дунд байлаа.

**Царацааны ажиглалт:** Ерөө, Мандал сумдын нутгаар өргөн далавчит таршаа, богино далавчит тоонолжилт царцаа 1мквд талбайд дундажаар 1-3 ширхэг тоологдсон. Бусад сумдын нутгаар царцаа ажиглагдаагүй.

**Пуужин зарцуулалтын тооцоо:**

2026 онд хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг ЦУОШГ-ын хангалтаар JFJ-3 пуужин 30 ширхэг хувиарлагдаж, 2025 оны үлдэгдэл 24 пуужин нийт 54 ш борооны пуужингийн нөөцтэйгээр үйл ажиллагаа эхлүүлсэн.

5 дугаар сарын 29-ны өдөр нэмэлт хангалт 42 ширхэг пуужин хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Нийт 4, 5 дугаар сард цаг агаарын нөхцөл бүрдсэн 12 процесст 28 удаагийн үйл ажиллагаа явуулж 59 ширхэг пуужин зарцуулсан байна.

Тайлан бичсэн:

ЦАЗН-ийн инженер:



М.Амарбаясгалан

УЦУОШТ-ийн дарга:



О.Ганбат